



Mongolia:
Enhancing Resource
Management through
Institutional Transformation

Монгол Улс. Институцийн
өөрчлөлт хийх замаар эрдэс
баялгийн менежментийг
сайжруулах төсөл

Хэлэлцүүлгийн аргууд

Joan McEwen
Long Term Technical Advisor

Олон нийтийн уулзалт

Оролцогч талууд, олон нийтийн төлөөллийг алба хаагч/зохион байгуулагч нартай уулзуулж, нэг болон олон тооны анхаарал татсан, санаа зовоосон асуудлаар хэлэлцэн зөвшилцөх

Олон тооны хүнд зөвлөгөө өгөх боломжоор хангах

Уулзалтын үеэр жижиг бүлгүүдээр хэлэлцүүлэг зохион байгуулж, санал хүсэлтийг нь авах боломжтой.

Сургалт / Семинар

Ихэнх тохиолдолд нэг болон түүнээс дээш хоног үргэлжилдэг томоохон сургалт, семинарын үеэр гол сэдэв, асуудлуудыг хэлэлцдэг.

Жижиг бүлгүүд олон төрлийн холбогдох сэдэв, асуудлуудыг хэлэлцэж болно

Хоёр талт уулзалт

Гол төлөв төрийн төлөөлөл, оролцогч талын төлөөлөл нэг нэгээрээ уулздаг.

Эдгээр уулзалтаар асуудлыг гаргаж тодорхойлох болон мэдлэгийн хүрээгээ тэлэх боломж олгодог.

Зорилтот бүлгийн уулзалт

Өмнө нь сонгогдсон бүлэг хүмүүс тодорхой бодлого, төсөл хөтөлбөр, асуудлууд дээр өөрсдийн санаа бодлоо илэрхийлэх боломжийг хангасан бүтэцтэй үйл явц юм.

Эдгээр нь асуудалд төвлөрөх хандлагатай байдаг

Ярилцлага / Ганцаарчилсан уулзалт

Ярилцлага авахаар бэлтгэгдсэн хүн өмнө нь сонгогдсон оролцогчдоос цуврал асуулт асууж, /төсөл хөтөлбөр, бодлого/ тодорхой сэдвүүдээр мэдээлэл цуглуулдаг.

Шуурхай утсан холбоо

Хүмүүсийн санал бодлыг сонсох зориулалттай утасны дугаар.
Энэ аргаар санал хурааж бас болно.

Санаа бодлын судалгаа

Судалгаанд оролцогчдоор асуулгын асуултуудыг эрэмбэлүүлэх, олон хариултаас сонгуулах, нээлттэй асуултад хариулт авах замаар судалгааны мэдээлэл, оролцогчдын санал бодлыг (зарим тохиолдолд зөвлөгөө өгөх) цуглуулах үйл явц юм.

Судалгааг шуудангаар, биечлэн, цахим хуудсаар болон утсаар авах боломжтой.

Судалгаанууд ихэнх тохиолдолд нэг стандарттай учир судалгаанд оролцсон хүмүүсээс адилхан асуулт авдаг ба ингэснээр хариултуудыг үнэлэн дүгнэхэд үр дүнтэй байдаг.

Олон нийтийн зөвлөх хороо

Хорооны гишүүд байнга явагддаг яриа хэлэлцүүлэг болон тодорхой зорилготой хэлэлцүүлэгт оролцдог.

Ихэнхдээ техникийн мэдлэг, суурьтай мэргэжилтнүүдийг оролцуулдаг.

Саналын хуудас / Ажлын дэвтэр

Оролцогч талуудыг тухайн сэдэвтэй холбоотой мэдээллээр хангаж, үүсээд байгаа асуудал бэрхшээлүүдэд гарц шийдэл гаргахыг уриалсан цахим болон хэвлэмэл материал.

Арга хэмжээ / Аялан танилцуулга

Ихэнхдээ семинараас цар хүрээгээр өргөн. Хүмүүсээс сонгож урих түгээмэл ч сонирхсон хүн бүр оролцох боломжтой байдаг.

Арга хэмжээг бүлгийн хэлэлцүүлэг, санал асуулга явуулах зэрэг оролцогч талуудын хэлэлцүүлэг хийх бусад аргатай нэгтгэх боломжтой.

Арга хэмжээ, аялан танилцуулгыг төслийг танин мэдүүлэх боломж гэдэг утгаар нь ашиглаж болно.



Forum

Форум

Форум нь бүлэг аль эсвэл байгууллага төлөөлсөн хүмүүсийн уулзалт юм.

Форумын оролцогчид гол төлөв орон нутгийн иргэдийн, улс төрийн, мэргэжлийн, эдийн засгийн, нийгмийн бүлгүүдийн төлөөлөл байдаг.

Вэб хэлэлцүүлэг

Вэб-д суурилсан хэлэлцүүлэг нь форум, блог, фэйсбүүк, интернетийн судалгаа, нийгмийн сүлжээ, рейтинг, санал асуулга, тоон систем бүхий телевиз гэх мэт янз бүрийн вэб дээр суурилсан оролцооны процессууд байдаг.

Вэб-д суурилсан үйл ажиллагаанууд нь хүмүүсийг хаана, хэзээ, ямар хугацаагаар оролцохоо шийдэх боломж олгодог.

Гудамжны үзүүлэн

Үүнд ханан дээрх зураг, үзүүлэн гэх мэт олны анхаарал татах зүйлс багтдаг бөгөөд олон тооны хүмүүсийн санал бодлыг сонсоход ашигладаг.

Төслийн газрын зураг, төлөвлөгөөний үзүүлэн зэргийг байршуулан, өнгөрч байгаа хүмүүсийн санал бодлыг асуух ба тодорхой асуудал, сэдвийн хүрээнд сонголт хийж саналаа илэрхийлэх боломжтой.

Эвхмэл танилцуулга / Мэдээллийн товхимол

Эвхмэл танилцуулга нь аливаа асуудал, үйлчилгээнд гарсан өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлэл хүргэх үр дүнтэй арга юм.

Энэхүү аргыг дангаар нь аль эсвэл үзэсгэлэн, компани т ажил зэрэгтэй хослуулан ашиглах боломжтой.

Товхимлыг илүү дэлгэрэнгүй мэдээлэл өгөх аль эсвэл удаан үргэлжлэх хэлэлцүүлгийн талаар шинэ мэдээлэл хүргэх зорилгоор ашигладаг.

Тэдгээрийг сэдэвчилсэн асуудлаар гаргаж авсан дэлгэрэнгүй баримт бичгүүдийг тайлбарлахад ашиглаж болно.

Иргэний саналын карт

Саналын энгийн картууд нь олон нийт ямар нэгэн үйлчилгээ, асуудлын талаар санал бодлоо илэрхийлэхэд зориулагдсан.

Саналын картыг албан байгууллагын санал хүлээн авах газар , санал хүлээн авах ширээн дээр байлгана.

Картны дизайн чухал: бөглөхөд хялбар, нүдэнд өртмөөр картуудыг хүмүүс их хэрэглэдэг.

Бөглөж байгаа хүний талаар нас, хүйс зэрэг үндсэн мэдээллийг асуух ба энэ нь хандлагыг тодорхойлоход тусалдаг.

Хурал зөвшилцөөн

Хоёр бүлэг байгуулах: нэг нь мэргэжилтүүдийн бүлэг, нөгөө нь асуудлын талаар санаа зовнисон иргэдийн бүлэг

Иргэдийн бүлэг мэдээлэл уншиж, гол асуултуудаа бэлтгэдэг. Тэд асуудлын үр дүнгийн талаар хэлэлцэж, өөрсдийн хүлээлт, санаа зовоосон асуудал болон зөвлөмж зэргийг багтаасан тайлан гаргана.

Мэргэжилтэнүүдийн бүлэг илтгэл тавьж, асуултуудад хариу өгнө.

Хурал нь олон нийтэд нээлттэй байна.

Дугуй ширээний уулзалт

Дугуй ширээний уулзалт нь зөвшилцөлд хүрэх, олон талт оролцогч талуудыг татан оролцуулах хэрэгсэл байж болно.

Дугуй ширээний уулзалт нь зөвшилцөлд тулгуурлан, орон нутгийн байгаль орчин, эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг дэмжих хамтын ажиллагааг бий болгож чадна.

Үндсэн байр суурь нь бүх оролцогчид, бизнесийн ашиг сонирхогчдоос орон нутгийн иргэдийн төлөөлөгчид хүртэл адил тэгш байх юм.

Дугуй ширээний уулзалт салбарын төлөөлөгчид, Засгийн Газрын төлөөлөл болон төрийн бус байгууллагуудаас бүрдэнэ.

АЖЛЫН ХЭСЭГ

Ямар нэгэн асуудлын талаар судалж байгаа мэргэжлийн баг, оролцогч талуудын төлөөлөл байна.

Ажлын хэсэг зөвлөмж бүхий тайлан бэлтгэн гаргадаг.

Цахим хурал

Компьютерын сүлжээгээр бүлгийн шийдвэрийг дэмжих програм ашиглан нүүр нүүрээ харан уулзалт хийн асуудлыг шийдэх, стратеги төлөвлөгөө боловсруулах, зөрчлийг арилгах, эрэмбэ дараалал үүсгэх, зөвшилцөлд хүрэх ажлуудыг хийх

Иргэдийн төлөөллийн хэсэг

Хүн амыг бүрэн төлөөлсөн хэдэн зуун иргэнээс бүрдсэн бүлэг төрөөс ирүүлсэн саналуудад хариу өгдөг.

Бүлгийг санамсаргүй түүврийн аргаар эсвэл мэдлэг, сонирхол дээр нь үндэслэн сонгон авч болно.

Судалгааны баг

Цөөн тооны хүнээс (5-20 хүн) бүрдсэн, урьдчилан сонгогдсон оролцогчид тогтмол уулзаж асуудлуудыг авч хэлэлцдэг. Ихэнх тохиолдолд туршлагатай чиглүүлэгч байдаг ба хэлэлцүүлэгт оролцохдоо баримтлах дүрэмтэй байдаг.

Судалгааны бага хурал

Янз бүрийн үзэл бодолтой олон тооны уригдан ирсэн хүмүүсээс (60-70 хүн) бүрдсэн бүлэг.

Зорилго нь мэдээлэл хуваалцаж, харилцан ойлголцолтой болсноор өөрсдийн хүсэн хүлээсэн ирээдүйг бүтээх юм.

Бага хурлын салбар хурлуудад төрийн, салбарын болон хэрэглэгч гэх зэрэг олон төрлийн төлөөлөл оролцдог.

Тинк танк / Эрдэмтдийн баг

Тулгараад буй асуудлыг шийдвэрлэхийн тулд мэдлэг, чадвар бүхий хүмүүсээс бүрдсэн том эсвэл жижиг бүлгийг байгуулдаг.

Энэхүү үйл ажиллагаа нь нэгээс гурван өдөр үргэлжлэх боломжтой.

Шийдвэр олох семинар

Санал бодол өөр өөр бүх ашиг сонирхлыг илэрхийлсэн хүмүүсийг цуглуулсан, асуудалд шийдэл олох семинар

Зөвшилцөх санал асуулга

Санал асуулга, хурал зөвлөгөөн, дугуй ширээний уулзалт зэргийг хослуулах арга юм. Тус үйл явцын эхэнд санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон бүлэг хүмүүс (40-100) санал асуулга бөглөнө.

Дараагаар нь оролцогчдод олон янзын хувилбар бүхий баримт бичгийг, тус хувилбарыг дэмжих, няцаах аргументын хамт өгнө.

Оролцогчид давуу болон сул талаар мэтгэлцэнэ.

Сүүлд нь оролцогчид хоёр дахь асуулгыг гүйцээгээд эхний ойлголтоос өөрчлөгдсөн зүйл байгаа эсэх үүний шалтгааныг үнэлж дүгнэнэ.

Делфи тооцоолол

Тухайн асуудлын талаар өөр өөр байр суурьтай бүлэг хүмүүсийг сонгож авдаг.

Оролцогчид нь саналаа өгч, асуудлыг хэлэлцдэг.

Хэлэлцсэний дараа, бүлгийн гишүүд асуудлын талаар санал бодол, хариугаа нэрээ нуун илэрхийлдэг.

Зөвшилцөлд хүрэх хүртэл санал солилцох ажиллагаа үргэлжилнэ.